

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад малчин, туслах малчдын хөдөлмөр нь улирлын шинжтэй, орлого нь тогтмол бус байдгаас шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөхөд бодит хүндрэл үүсдэг. Үүний улмаас нийгмийн даатгалд хамрагдалт тасалдах, тэтгэврийн эрх бүрэн хангагдахгүй байх эрсдэл бодитоор оршсоор байна.

Монгол Улсын хэмжээнд 2026 оны статистикийн тоогоор 313,195 малчин бүртгэлтэй бөгөөд 195.526 малчин өрх байгаагаас 147,842 малчин зээлтэй, нийгмийн даатгалаа төлж буй 112,365 малчин байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд малчин, туслах малчдын шимтгэл төлөлтийн хугацааг сар бүр төлөхөөр зохицуулсан. Тус зохицуулалт нь малчин, туслах малчны нийгэм, эдийн засгийн нөхцөлд хэрэгжихэд хүндрэлтэй, бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байна. Иймд шимтгэл төлөлтийг жилийн орлогын мөчлөгтэй уялдуулан, жилд хоёр удаа хуваан төлөх боломжийг хуульчлах шаардлага үүссэн.

Малчны нийгмийн даатгалын шимтгэл төлөхтэй холбоотой харилцааг Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиар зохицуулж байсан. Уг хууль нь 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсанаар хүчингүй болсон. Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9.хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх; гэж заасан. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө гэж заасны дагуу эрх зүйн үйлчлэлгүй болсон.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээрийн 23 дахь хэсэгт дараах заалт нэмсүгэй:

“21.23.1.энэ хуулийн 21.23-т заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг улирлын шинж чанартай орлоготой уялдуулан жилд хоёр удаа урьдчилан төлнө;

21.23.2.энэ хуулийн 21.23.1-т заасан хуваан төлөлт, хугацааг гэрээнд өөрөөр харилцан тохиролцож болно.”

2 дугаар зүйлд Энэ хуулийг дагаж мөрдөх хугацааг заасан.

Олон улсад улирлын болон бие даасан хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын зохицуулалтыг уян хатан байдлаар шийдвэрлэсэн жишиг түгээмэл байна. Тухайлбал, Олон улсын туршлагыг авч үзвэл Европын ихэнх улсад “малчин” гэх нэршлийг тусгайлан хэрэглэдэггүй боловч фермер буюу хөдөө аж ахуйн салбарт өөрөө

хөдөлмөр эрхлэгчдийг (agricultural self-employed) ердийн хөдөлмөр эрхлэгчдээс ялган, тэтгэврийн тусгай тогтолцоогоор зохицуулдаг бөгөөд Францад фермерүүдийн тэтгэврийн тусгай сан (Mutualité Sociale Agricole), Германд Хөдөө аж ахуйн тэтгэврийн сан (Landwirtschaftliche Alterskasse) зэрэг даатгалын бие даасан тогтолцоо ажиллаж, шимтгэлийг орлогоос уян хатан тооцох, биеийн хүчний өндөр ачаалал, хөдөлмөрийн эрсдэлийг харгалзан зарим тохиолдолд эрт тэтгэвэр тогтоох, төрөөс татаас олгох зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Нордик болон Альпийн бүсийн улсуудад, тухайлбал Норвеги, Швейцарт уулын бүсийн мал аж ахуй эрхлэгчдийг байгаль, цаг уурын хүндрэлтэй нөхцөл, улирлын эрсдэл, алслагдсан байршлыг харгалзан шимтгэлийн хөнгөлөлт, тэтгэврийн нөхөх коэффициент, эрт өндөр насны тэтгэвэр тогтоох зэрэг тусгай зохицуулалтай байна. Төв Азийн орнуудаас Казахстан, Киргизстанд нүүдлийн болон хөдөө аж ахуйн салбарт өөрөө хөдөлмөр эрхлэгчдэд сайн дурын, хөнгөлөлттэй шимтгэлийн тогтолцоо, орлого тодорхойлох боломжгүй тохиолдолд стандарт дүнгээр шимтгэл тооцох, зарим нөхцөлд эрт тэтгэвэр тогтоох зохицуулалт хэрэгждэг байна. БНХАУ-д хот, хөдөөгийн хүн амын тэтгэврийн тогтолцоог салгаж, хөдөө орон нутгийн хүн ам, түүний дотор малчдыг хамруулсан Хөдөө аж ахуйн тэтгэврийн систем (Rural Pension Scheme)-ийг хэрэгжүүлж, харьцангуй бага шимтгэл, бага тэтгэврийн тогтолцоотой байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд “малчин”, “туслах малчин” гэх нэр томъёо орсон. Уг нэр томъёо нь шинэ нэр томъёо биш бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-т “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;”, Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-т “Туслах малчин” гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно. Бусдын малыг бие даан хөлсөөр маллахтай холбогдсон харилцааг Иргэний хуулиар зохицуулна.” тус тус заасан байдаг.

Энэхүү хууль батлагдсанаар малчин, туслах малчин нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа нөхцөл арилж сайн дурын үндсэн дээр нийгмийн даатгалаа төлөх нөхцөл бүрдэх юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ